

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Захиргааны ерөнхий хуулийн дараахь заалт, тайлбарыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт, тайлбар:**

“3.1.7. Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, түүнийг хэрэгжүүлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа.”

**2/5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт:**

“5.1.1. төрийн захиргааны төв болон төрийн захиргааны бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага;”

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 4 дэх өгүүлбэрийн “захиргааны” гэснийг тус тус хассугай.

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2018 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсантай холбогдуулан захиргааны хэргийн шүүхээс Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан үүсгэсэн захиргааны хэргийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу хэрэгсэхгүй болгоно.

Гарын үсэг